



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 629

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2020 оны эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 185,716,248.00 (нэг зуун наян таван сая долоон зуун арван зургаан мянга хоёр зуун дөчин найман) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Д.Должин нарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтыг сайжруулан, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн эд хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

2.2. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах;

2.3. Төрийн өмчид эд хөрөнгө олж авахдаа хууль тогтоомжид заасны дагуу зохих зөвшөөрөл авах;

2.4. Байгууллагын Дорнод аймаг, Хэрлэн сум, 2 дугаар баг, Зүүн дөрвөн замын урд байрлах 60 м.кв талбай бүхий эзэмшил газар, Хан-Уул цогцолбор сургуулийн зүүн урд талд байрлах 80 м.кв талбай эзэмшил газрын зааг, хэмжээг мэргэжлийн байгууллагаар нарийвчлан тогтоолгох, кадастарын зургийг шинэчлэн гаргуулах;

2.5. Цаашид үлдэх өртөггүй, ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох санал боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх;

2.6. Төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлэх тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авах;

2.7. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолд нийцүүлэн батлах;

2.8. Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй акталж данснаас хассан, ажлын хариуцлага алдсан ажилтан, тооллогын комиссын бүрэлдэхүүн, тэдгээрт хяналт тавих чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцож холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг таслан зогсоох;

133007100

2.9. Төрийн өмчийн эд хөрөнгийг хоёрдогч түүхий эдээр худалдан борлуулж олсон орлогыг зориулалтын дагуу зарцуулах, урсгал төсөв санхүүжүүлэхийг хориглосон заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

2.10. Хөрөнгийн ашиглалт, өртөг зардлыг зөв тооцох үүднээс хөрөнгө бүрийн ашиглалтын хувийн хэргийн Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах;

2.11. Тогтоолын хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад бүртгэлээр болон тогтоолын биелэлтэд тавих хяналтыг сайжруулахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
649 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг  
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Дутагдсан, биетээр байхгүй хөрөнгийн талаар	0.8	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12 зүйлийн 2 дах хэсгийн 12.2.2, 12.2.3 дэх заалт	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
2	Зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн зөрчил дутагдал	62.35	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2, 4.3, 4.10 дах заалт	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай" мөрдөж ажиллах
3	Арслантай барилгыг бусдад үнэ төлбөргүй ашиглуулсан	3.75		
4	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 өрөө, 3 ширхэг орон сууцыг өөрийн ажилтнуудад ашиглалтын зардлаар нь үнэ төлбөргүй ашиглуулсан	30.08	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 49 дүгээр тогтоол
5	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, акталж данснаас хассан хөрөнгө	34.64	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дах хэсэг	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон

				орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” мөрдөж ажиллах
6	Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийхдээ ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг үнэлсэн, дахин үнэлгээнд хамрагдсан хөрөнгийн бодит үнэ цэнийг санхүүгийн тайланд тусгасан боловч санхүүгийн программд ашиглах жилийг алдаатай оруулсан	-	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” А-1/3549 дүгээр албан бичиг	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах
7	Газар эзэмших эрхийг үнэлэхдээ газрын хэмжээг газар дээр нь нягтлан шалгалгүй үнэлсэн байна. /60 м.кв, 80 м.кв талбай бүхий газрыг хашаалаагүй байсан/	-		
8	Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр 10.41 сая төгрөгийн балансын үнэтэй, 9.15 сая төгрөгийн балансын үнэтэй 2 орон сууцыг 1 орон сууц гэж бүртгэсэн	19.56	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаал,	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, нэгтгэж бүртгэсэн 2 орон сууцны бүртгэлийг салгах

9	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлээгүй /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 490 дүгээр тогтоол/	34.54	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.2 дах заалт	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын дагуу ажиллах.
<b>Нийт дүн (мөнгөн дүнгээр)</b>		<b>185.72 сая.төг</b>	(нэг зуун наян таван сая долоон зуун хорин мянга)	